

## АЯЛАЛ, ТЭМДЭГЛЭЛ

ДЭЭД МОНГОЛД АЯЛСАН  
ТЭМДЭГЛЭЛ

М. Зэнээ

Монголчууд мандаж явах үедээ нүүдлийн соёлоо хадгалан цаг агаар, өвс бэлчээр, унд усны аятай таатайг даган Төв Азийн нутагт сэлгэн нүүдэллэсээр ирсэн түүхэн ул мөр олон байдаг. Гэвч миний морины туурай хүрсэн газар Монголын нутаг хэмээн «Цагийн сайнд» тооцож байсныг бид өвгөдөөсөө өвлөж, өнөөдөр түүгээр ер бахархаггүй байна. Гэхдээ монголчууд Азид төдийгүй дэлхий дахинд тархан суурьшсан түүхийг бид үгүйсгэх аргагүй. БНХАУ-ын Хөх нуур мужийн Дээд монголчуудын нутгаар айлчилсан тухай багахан тэмдэглэлийг уншигч түмэндээ өргөн барьж байна.

## 1. Түүхэн төвч

Мин улсын үе буюу 1510 оны үед Хөх нуурын Хатан гол, Шар мөрний сав газар одоогийн Өвөр Монголын монголчууд шилжин очиж, тэнд байсан тангадуудыг нуурын өмнө тал руу шилжихэд хүргэжээ. Энэ үеэс Хөх нуурын баруун тол монголчуудын мал маллан амьдрах нутаг бэлчээр болсон түүхтэй. Тэр үед ордосынхан түмэд нар энд суурьшин байв. 1632 онд Монголын халх аймгуудын хоорондын хямрал ихэлсэнээс Цогт тайж ард, албатаа дагуулж Хөх нуурт очиж эзлэн суужээ.

XVII зууны эхэн үед Синьцзяны орчим нүүдэллэн мал аж ахуй эрхэлж байсан Ойрад монгол ихэд хүчирхэгжиж 1636 онд Ойрадын Хошууд аймгийн Гүүш хаан Ил, Тариймын хотгороор дамжин 1637 онд Хөх нуурт хүрч одоогийн Улаанцаангийн нутагт ирж, түм гаруй цэргээр Цогт тайжийн гурван түмэн цэрэгтэй тулалдсан байна. Энэ тухай тусад нь бичих хэрэгтэй болов уу. Цаг үе, шашин суртахуун, үзэл бодол, хэтийн зорилго дангаар ноёрхох санаархлаас үүдсэн энэ тулалдаан «Хоноц хоноцдоо дургүй, хонуулсан айл хоёуланд нь дургүй» гэдгийн үлгэр болж байсан түүхэн энэ үед Цогт тайжийн цэргийг Гүүшийн цэрэг ихэд дарсан тэр газрыг одоо их, бага улаан гэж нэрлэж буй нь олон хүний амь үрэгдэж, их цус урссаныг илтгэнэ. Энэ цагаас одоогийн Хайши буюу Нуурын баруун дахь нутаг бэлчээр хошууд аймгийн мэдэлд орсон байна. 1654 онд Гүүш хаан нас барж, 5-р Далай лам Хөх нуурт төлөөний хүн томилон тайж нарын хурал хийж Хошууд аймгийг зүүн, баруун хоёр гар болгон нөлөөндөө оруулжээ. 1723 онд Гүүш хааны жич хүү Лувсанданзан Чин улсыг эсэргүүцсэн бослого гаргасны дараагаас төрийн ноёрхлыг чагналах ажил хийж Дээд Монголыг 1725 онд хоёр аймаг, 29 хошуу болгон бутраасан байна. Энэ үеэс Хөх нуурын Монгол, төвд угсаатныг Хатан голын хойд, өмнөд биеэр нутаг заан суурьшуулсан түүхтэй. Тэр цагаас 300 гаруй жил энэ нутагт монголчууд нүүдлийн соёл, зан заншил, хэлээ ерөнхийдөө хадгалан өнөөг хүртэл амьдарсаар байгаа ажээ.

## 2. Өнөөгийн байдал

1991 оны 9-р сарын 29-нд Хөх нуур мужийн Шинэн хотод очиж Баруун хойд тойргийн зочид буудалд буусан юм. Тэнд иргэд дүүрэн, монгол, хятад нь үл ялгагдах болохоор хятад орны зах хязгаарын хүн багширсан нэгэн жирийн хотод очсоныг эрхгүй илтгэнэ. Ар Монголоос хүн ирж гэсэн чимээ чих цохисон дээд монголын хүмүүс цөөн бүлгээр

ирж, нутаг орны сонин сайхныг дуулан, өөрсдийн амьдрал байдлыг танилцуулах, гэр орноороо урьж, хэдэн өдрийг зугаатай өнгөрүүлэв. Тэд хотын шуугиант амьдралд дасан, аж төрөх ажээ. Монгол ёсоор амар мэнд мэдэлцэн идээ ундаа, архи дарс, жимс тэргүүтнээ ширээ дүүрэн овоолж, хоол ундаар дайлан зарим нэг нь Монголд очиж үзэж харснаа бусаддаа сонирхуулан, түүнийгээ биднээр батлуулан тайлбарлана. Хөх нуурт амьдардаг дээд монголын өмнөө барьдаг зарим сэхээтэн хоёр улсын найрамдал сайжирсан сүүлийн хоёр жилд Монгол улсад амжин ирж, ах дүүгээ олж, анд найз нөхөртэй болоод авчээ. Тэдний яриагаар БНМАУ-д очихад гайхмаар сайхан нь үнэхээр монгол хүмүүсийн дунд, жинхэнэ монгол оронд очсоноо сая мэдэрдэг гэнэ. Айлд ч, албан газар ч, хөдөө гадаа, хот сууринд ч монгол хэлээрээ ярьж, ойлголцох нь нэн таатай байснаа гайхна. Газар нутгийн уудам, өвс бэлчээрийн сайхан, хүн ардын зочиломтгой зан ааль, цагаан идээний элбэг дэлбэгт тэд бахархах ажээ. Гэтэл бас сэтгэлд таалагдахгүй зарим зүйл байсныг ч санаа алдан үе үе цухалзуулна. Тэр нь хүмүүс ажил хийхээ байсан, хар зах дээрээс болох болохгүй юм үзэж харж болох тухай, ганц хоёрхон жилийн дотор мөнгөний ханшаа унагааж, гадаад валютын эрхшээлд орж байгаа, өөрсдөө юм хийхгүй, санаачлахгүй, тэгээд хэт улс төржиж байгаа, хэсэг бүлгээрээ нам, эвсэл, холбоо, хөдөлгөөн, яс үндэс үзэл бодлоороо салж бутрах байдалтайд сэтгэл зовж байгаагаа илтгэнэ. Монгол улсад айлчилсан дунд зэргийн насны юм үзэж, нүд тайлсан нэгэн эр надтай танилцаад «Та МАХН-ын Төв Хорооны гишүүн хүн байна. Танд гэж хэлэхэд танай төр засгийн удирдлагад дээгүүр алба хашдаг нэгэн хүний гэргий надтай ярихдаа «манайд хамгийн ухаалаг, ажилсаг, улс орныг авч явах хүмүүс нь эрлийзүүд байдаг гэсэн. Ийм хүмүүс танайд тийм олон байдаг юм уу» гэж сонирхож билээ. Тэгээд хариуд нь тийм хүмүүс цөөнгүй байдгийг бид мэднэ. Манайд хүмүүсийг яс үндэс, гарал үүсэл, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаж үздэггүй боловч тодорхой хүмүүс зохион байгуулалттай, зорилго чиглэлтэй, нэгдмэл маягаар ард түмэн, эх орны эрх ашигт харш үзэл баримтлал, үйл ажил явуулбал анхаарч үзэхээс аргагүй болох цаг ирж ч магадгүй юм. Монгол улсыг монгол хүн удирдаж, монголчууд эх орондоо эзэн болж, хамгийн ухаалаг, ажилсаг улс орноо авч явах хүмүүс нь монголчууд өөрсдөө байгаасай гэж бид хүсч явдаг. Хэрэв тэгж ярьж байгаа хүний бодсон шиг асуудал эргэвэл, тодорхой цөөнхид эрх ашиг үйлчилбэл хожмын өдөр хойчийн маргааш Монголын хүн амын цөөнх нь монголчууд болж, эх оронгүй цагаачдын нутаг дэвсгэр болон хувирахгүй гэсэн баталгаа ч байхгүй л дээ. Америкийн уугуул оршин суугч индианчууд үндэсний цөөнх болж, шахан хавчигдаж, арай ядан хөлсний хөдөлмөрөөр бусдын эрхшээлд толгой гудайн амь зууж, тэнд гаднаас очсон цагаачид төр, засаг, бүх шатны эрх мэдлийг атгаж байгаа түүхийг бид мэддэг гэж ярьж тайлбарласан билээ. Ингээд бодохоор Монгол улс гадны нүдээр харахад анхаарч үзмээр зарим асуудалтай битүү тулгараад байгааг болгоож үзүүштэй болсон ч байж магадгүй гэж санагдсан. Шинэн хотод хэд хоноод Хөх нуурын баруун талд оршин суух дээд монголын нутгийг зорин хөдөлсөн. Бүтэн өдөр шахуу Хөх нуурын өмнөд биеийг ороон давхиж, монголчууд оршин суух Улаансяний Цакиа балгас буюу Баян сумын нутагт орж ирсэн. Тэнд анхны дөрөө мулталсан айл малчин Жигмэд гуайнх болов. Таван ханатай монгол гэртээ тухлан сууж, тараг сүү, архи дарсаараа дайлсан тэр айлын эзэгтэй манай хөдөөгийн эрүүл агаар нь эм болсон малчин айлын монгол эмэгтэйг санагдуулсан. Тэртээ 300 гаруй жилийн өмнө энэ нутагт ирж

суурьшсан монголчууд үндэсний уламжлалт зан заншилтай байгаад сэтгэл хөдөлж, баярлан бахархсанаа нууж чадаагүй билээ. Гэрийн дотор хос авдар, сав суулгын тавиур, аяганы ширээ, хананд тулган хураасан унтах өнгөц, гудас, хөнжил, цагаан хэрэглэл, дуу хураагч, зургийн жааз, толь гээд ер л одоогийн монгол айлд байдаг жирийн тавилга хэрэгсэл байх ажээ. Ирсэн зочдод зориулж, хоймор талдаа хивс дэвсэж, идээ ундаа дэлгэн зочилон дайлах нь хэдэн мянган бээрийн зам туулсан надад хөдөөгийн монгол ах дүү нартаа тухлан саатах адил болсныг хэлэх юун. Тэд Ар Монголын талаар гөйд сонирхон, үг яриа нийлж, үзэл бодлоо ойлголцож байгаадаа баярлан үүх, түүх, өнөөгийн сонин хачиныг хүүрнэх зуур байн байн идээ ундаагаа барин хүндэтгэл үзүүлж байсан. Тэд өвөл нь өөрсдийн барьсан байшиндаа сууж, дулаан орохоор гэрээ авч өвсний сор, усны сайныг даган оторлож явдаг юм байна. Цаг агаар, ус ургамлын хувьд Монгол орны говь хээрийн бүсийнхтэй ойролцоо мэт, хариулдаг мал нь хонь, ямаа, үхэр, тэмээ, сарлаг, илжиг, адуу, нутаг нь ерөнхийдөө далайн төвшинөөс дээш уул нуруу нь эгц өндөр, сүрлэг, агаар нь сийрэг, зарим газраа нам доор, боломжтой газар нь ихэнхдээ хятадууд тариа тарьсан, бэлчээр нь дэрс хужир ихтэй, уулархаг газраа малчид нь шахагдсан нутаг байв. Хөх нуур муж дахь дээд монголчууд Улаан сянь, Дулаан сянь, Дэлэхэ хот зэрэг хэд хэдэн газар гол төлөв оршин суудаг юм байна. Дээд Монголд ойролцоогоор 70 мянга орчим монголчууд оршин суудаг ажээ. Тэд сүүлийн үед түүх, хэл, соёлоо анхааран үзэж, судалж, ном хэвлэл гаргаж байгаа гэнэ. Миний очсон гол газар Улаан сянь бөгөөд тэндхийн монгол эмнэлгийн хорооны захирал Бандижагийн гэрт зочилж, дээд монголчуудын аж амьдралтай түр боловч танилцах завшаан тохиосон билээ. Бандижа гэртээ ам бүл 6-уул. Эхнэр Сономцоо нь айл гэрийг авч яваа хос баганы нэг, эгэл жирийн, ажилсаг даруу монгол бүсгүй. Тэдний ах дүү, төрөл садан хөдөөд мал маллаж, аятай тохитой амьдрах ажээ. Бандижагийн авга ах Наажаяа гуай улаан туйпуугаар барьсан хэрмэн хашаанд 9 тасалгаатай тохилог сууц барьж, эд юм хийх, түлээ нүүрс хадгалах тус тусдаа пинтэй, саалийн үнээ чөдрийн морь байлгах тэжээлийн жижиг хашаа, малын том хашаа саравчтай ихээхэн тухлаг амьдарч байхыг сонирхон үзсэн юм. Тэднийх 700 гаруй хонь ямаа малладаг ажээ. Эндхийн дийлэнх мал хувийнх учраас өсгөх сонирхол ихтэй, малын түүхий эдээ борлуулах, юмханаар юм хийх, хайрлах сэтгэл сайтай байдаг байна.

### 3. Бурханы орон Гүмбум

Хөх нуур мужийн төв Шинэн хотоос цаг шахам давхиад эртний домогт шашны гол газар, Гүмбум (төвдөөр буман бурхан гэх утгатай) хийд ордог. Энд төвд, монгол, хятад таван хэлийн улс цуглан бурханд мөргөж, буян үйлдэж, сайн сайхныг мөрөөдөж сүслэн залбирч явахын зэрэгцээ худалдаа наймаа, зах дэлгүүр зээл гудамжаар өдөр бүр алаглан багширна. Нутгийн хүмүүсийн тайлбарлахаар бурхны орон Гүмбум нь буддийн шашны урсгал шарын шашныг үндэслэгч их лам Богд Зонхов (1357—1419) мэндэлсэн газар гэнэ. Бурханы шашин хөгжлийнхөө нэгдүгээр үеэ дуусгаж, буурах хандлагатай болсон үед түүнийг авч явах хувь зохиолтой их богд, бурхан багшийн хойд дүр гэгдсэн Богд Зонхов мэндэлсэн хэмээх тэр газар сүсэг бишрэлтэй ард түмэн сүм дугана байгуулан үеийн үед тахин шүтэж иржээ. Богд Зонховын мэндэлсэн газар түмэн навчтай их зандан ургаж, түүнийг тойруулан хамгаалсан дугана байгуулсан гэх бөгөөд тэрхүү зандан модноос ургасан навч маанийн үсэгтэй байдаг гэсэн домог яриа байх

ажээ. Гүмбум хийдийн байрших тэр ууланд нэг монгол үхэртэй ядуу эр, эм хоёр амьдран суудаг байжээ. Эмэгтэй нь бие давхар бөгөөд нэг өдөр үхрээ хөтлөн усанд яваад буцах замдаа тулгар эх өвдөж, нэгэн хадны дэргэд амаржсан байна. Тэрхүү амаржсан газар буман навчтай зандан ургажээ. Амаржсан эхийн эхсийг (хойдохыг) булсан газар бас нэг зандан мод ургасан юм гэнэ. Шашныг шинэ байдлаар сэргээн мөнхжүүлж, гелугва ёсыг системчилсэн богд Зонховын мэндэлсэн гэх тэрхүү ууланд түүний гэгээн дурсгалыг хүндэтгэн барьсан Гүмбум хийд, түүний байдалтай ийнхүү танилцаж, тэр хийдийн мөнх зулд 78 настай эх, ах дүү нарынхаа илгээсэн шар тосыг өргөн хандивлаж, хийдийн гэгээн лам нартай уулзан учирч явахад тэд монгол оронд шашин хэр зэрэг байдгийг ихэд сонирхон асууж байсан. Гүмбум хийдийн нэр хүндтэй Шинаа гэгээний гэрт айлчилан золгож, цаг гаруй санал солилцон, хамт зургаа авахуулсан дурсгалт мөчийг мартаж аргагүй. Энэ гэгээн «соёлын хувьсгалын» үед хийдээсээ өөр газар суух болж тусгай харгалзлалд байсан гэнэ. Гэгээний байсан тэр газар байгаль цаг уурын ямар ч нөхцөлд сайхнаараа байдаг болохоор нутгийн улс бишрэн хүндэлдэг байсан тухай хүмүүс ярьцгаах ажээ. Гүмбум хийдэд хэд хэдэн гэгээн байдаг ажээ. Тэдний нэг Ажаа гэгээн нэлээд нэр хүндтэйд ордог юм байна.

#### 4. Монгол, төвдүүдийн байдал

Энэ нутаг монгол, төвд угсаатнууд холилдон сууж, мал маллан амьдрах бөгөөд шашны хувьд нэг учир олон талаар зохицон байх боловч бэлчээр нутгийн болоод үндэстний явцуу үзлээр харшилдах явдал ч байдаг ажээ. Төвдүүд өрөөсөн ханцуйгаа сугалдаргалсан захгүй дээл өмсөж, монголчууд нь монгол дээл, хятад хувцас, заримдаа төвд хувцас ч өмсөж явна. Төвд ба хятадууд үндэснийхээ онцлогийг уламжлан хадгалах нь илүүтэй байдаг мэт санагдана. Төвдүүд майхан эсвэл утаа, май тавьсан муухан шавар оромжинд амьдралын нөхцөлийг нэг их харгалзахгүй дээл хувцастайгаа эгэл борогжуу амьдрах ажээ. Тэд их угаалга үйлдэх нь буян заяа арилах уршигтай гэж үзэх болохоор хувьсгалын өмнөх шарын шашны номлол сурталд автагдсан эгэл борогжуу монгол амьдралыг эрхгүй санагдуулна. Бүсэндээ хэт хутга, том балнус хавчуулсан хүдэр хүрэн эрчүүд, үсээ навшийтэл ширэлдүүлсэн хээгүй байрын эмэгтэйчүүд малгай тавибал манайх, маргааш болбол хүнийх гэсэн байдлаар чөлөөтэй хэсэн амьдрах энэ нутагт зарим нь монгол айлын мал хариулан жилдээ нэг мянга шахам юаны орлоготой амь зуух нь үзэгдэнэ. Эндхийн монголчуудын зарим нь хятад, төвдөөр ярьж чадах ба төвдүүдээс илүү тохилог амьдрахыг хүснэ. Тиймээс ч тэд нүүдлийн хятадуудаар аятайхан байр байшин бариулан, олсон хэдийгээ өөртөө зарцуулж чадах мэт. Төвдүүдийн дотроос дээд мэргэжил эзэмшиж эмч, багш болсон улс ч цөөнгүй. Арвайн гурил шар тостой зуурч идэх нь тэдний амьдралын гол онцлог байх ажээ. Өндөр ууланд сарлаг хариулан өтгөн сүүтэй цай ууж, мах идэж, тослог ихтэй хоол унд хэрэглэн амьдрах төвдүүд уул хадандаа сарлагтайгаа цуг авирч, буун бусдаас илүү байгаль орчинтойгоо зохицон амьдрах ажээ. Цэвэр байгалийн бүтээгдэхүүн болсон төвдүүд өвлийн хүйтэнд дан майханд даарч хөрсөн, шинжгүй даархыг юман чинээ бодохгүй амьдрахыг харсан дулаан байрны нүүдлийн бидэнд тэдний тэсвэр хатуужилтай, дан хувцастай хүүхэд нь хүртэл эрхгүй нэгийг бодогдуулна.

Хүн гэдэг амьтан ямарч бэрхшээл зовлонг дааж, байгаль нийгмийн шалгарлыг даван туулж амьдарч чаддаг боловч хичнээн ая тух-

тай элбэг хангалуун байх тусам төдий ихийг хүсч мөрөөдөж, урагш тэмүүлэн бүхний дээр, бүхнээс илүү сайн сайхан байхыг оролддог хязгааргүй хүсэл тэмүүллийн жишээ гэдэг нь харагдана. Төвдүүдийн ийм хээгүй хээрийн амьдрал тэдний гүнд орж ажиллаж амьдрах хүсэлтэй хятад хүмүүсийн таашаалд нийцэхгүй учир арга буюу хөл хөндий байхад хүргэдэг нь төвдчүүдийн хүсэл зорилгод нийцдэг мэт санагдсан. Төвд, монгол угсаатнууд бэлчээр нутгийн маргаанаас болж эв эвдрэх явдал цөөнгүй гардаг ажээ. Намайг тэнд байхад зуу гаруй төвд, 40 гаруй монголчууд нутаг бэлчээр булаалдан хоорондоо гардан тулалдаж гурван төвд амь үрэгдсэн байлаа. Мөн хэдэн төвд хүн Хөх нуурын Улаан сяний харьяат нэг монгол ламд халдсанаас болж монгол эмнэлэгт ирж хэвтсэнтэй тааралдсан юм. Ийм явдал нэг биш удаа гардаг тухай, тэднийг зохицуулах гэж дарга нар нь их хүч чармайлт гаргадгийг ойлгож мэдсэн юм. Гэвч ерөнхийд нь авч үзвэл төвд, монголчууд харилцан бие биенээ ойлгож, эв зүйгээ олж амьдардаг бололтой. Төвдүүдийн дотор домог болон яригдлаг нэг зүйл бол Хятадын хааны Вэньчун гүнж хэмээх гайхамшигт сайхан хатныг Соронзонгомбо (617—649) хаан хатан болгон авсан тухай яриа юм. Хятад хөрш зэргэлдээ өөр үндэстнийг үзэсгэлэн төгөлдөр, ухаантай сайхан эмэгтэйн өнгөөр татаж, мөнгөөр тэтгэж ирсэн бас нэгэн бодит түүх өнөөг хүртэл төвдүүдийн дотор хадгалагдаж байгааг үүнээс харж болох мэт. Хөх нуур мужийн төв Шинэн хот (уучин Сэлэм хот)-оос Хөх нуурын зүг явахад замд «Нар, сарны хөтөл» гэж далайн төвшинөөс гурав дөрвөн мянган метр өргөгдсөн уулын өндөр хотол дээр гардаг. Тэр нар сарны хөтөл дээр Вэньчун гүнж Соронзонгомбо хааны хатан болон хүргэгдэж явахдаа хүний нутгийн дээсэн дээр эцэг эх, нутаг орноо эргэн санаж, уйлж дуулсан домогтой ажээ. Энэ хөтөл дээр Вэньчун гүнжийн дурсгалд зориулсан, түүний үйл амьдрал, Төвд дэх үйл ажиллагаатай нь холбоотой элдэв зураг дүрслэл хананд нь урласан гурван байшин барьж нааш цааш зорчигчдод үзүүлэн хятад, төвдийн найрамдалт харилцаа, ах дүүгийн салшгүй урагийн холбоог сурталчилдаг юм байна.

### 5. Хамтын ажиллагааны төлөв

Миний бие Хөх нуур дахь дээд монголчуудын нутгийг зорьсон гол зорилго бол монголчууд цаашид холбоо, харилцаатай бие биедээ туслах, бие биеэ ойлгож, хамтран ажиллаж харилцан дэмжилцэхэд ямар алхам хийж болохыг сонирхоход оршиж байснаас биш, зарим нэг ховживийн сонинд бичсэнээр хятадад ардчилалыг нухчин дарсан туршлага судлахаар яваагүйг хэлэх ёстой болов уу гэж бодлоо. Бидэнд хамтран ажиллаж, харилцан туслалцах, бие биедээ туслах, ойлголцох бодит боломж байгааг тэмдэглэхийг хүсч байна. Энэ нь монгол-хятадын харилцаа цаашид өргөжин хөгжих бодит боломж нээсэн хоёр орны төр, засаг, намын хамтын ажиллагаатай холбоотой билээ. Бидэнд соёл, шинжлэх ухаан, урлаг, эрүүл хамгаалал, үйлдвэр, аж ахуй, худалдаа зэрэг олон талаар хамтарч үйлс бүтээх боломж байна. Хөх нуурт очоод Улаан сяний орлогч дарга Мо И-шинтэй ярилцан жилд мянган тонн цаас үйлдвэрлэх цаасны үйлдвэр байгуулахаар тохиролцож урьдчилсан гэрээ байгуулж ирсэн юм. Энэ гэрээг Хөдөлмөрийн яаманд танилцуулж, ач холбогдлыг нь ойлгуулахыг оролдсон. Уг үйлдвэрийг байгуулахад зохих хэмжээний гадаад валют орох боловч улсын хэмжээнд авч хэлбэл Улсын банкны барилгыг засуулахад зарцуулсан 3 сая долларын гуравны нэгээр Монгол улс нэг цаасны үйлдвэр байгуулах боломж байсан. Гэвч манай эрх банди нар ардчилалын

хоёр жилд төр, засгийн нэрээр ард түмний хөрөнгөөр тогтносоос болоод улсын гадаад валютын сан хоосорч, хүнд байдалд орсон нь ийм асуудал шийдэхэд зохих ёсоор нөлөөлсөн нь илэрхий. 300 гаруй жилийн өмнө эх нутгаасаа алслан түүхийн хатуу ширүүн нугачааг туулан амьдарч яваа дээд монголчуудад аз жаргал, эрүүл, энх, сайн сайхан бүхнийг хүсч, Монгол улсаас өнгөрч буй хонин жил, ирж буй бичин жилийг тохиолдуулан дурсамж тэмдэглэлээ өндөрлөн өргөн барив.

Жич: Дээд монголын түүх, соёл, өнөөгийн байдлыг сонирхогчид болон судлаачдад хэрэг болох болов уу хэмээн зарим ном, зохиолын нэрийг энд дурдсаныг минь болгосно уу.

1. Tear Lamasery. Qinghai people's publishing house, 1987.
2. Chaidamu today, Qinghai, 1987.
3. Цэцэгт цайдам (сэтгүүл)., 1991, № 1—4. (Худан монгол бичгээр),
4. Өгүүллийн түүвэр. 1987 он, (Худан монгол бичгээр).
5. Qinghai Li Shi jan she (Хөх нуурын түүхийн тойм), Шининь., 1987, (Хятад хэлээр)